



ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 08 сарын 21 өдөр

Дугаар А/254

Улаанбаатар хот

Хөдөлмөрийн дотоод журмын 6.20.3
дахь заалтын хэрэгжилтийг түр
хугацаагаар түдгэлзүүлэх тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсэг, Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын зөвлөлийн 2023 оны 14 дүгээр хурлын 02 дугаар шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Иргэний нисэхийн тухай хууль шинэчлэн батлагдсантай холбогдуулан хуулийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангах, Иргэний нисэхийн ерөнхий газрын зохион байгуулалтын бүтэц, орон тоонд өөрчлөлт орсонтой холбогдуулан нисэхийн аюулгүй ажиллагаа, аюулгүй байдал болон үйлдвэрлэлийн хэвийн ажиллагааг хангах зорилгоор Иргэний нисэхийн ерөнхий газрын Хөдөлмөрийн дотоод журмын 6.20.3 дахь заалтыг 2023 оны 08 дугаар сарын 21-ний өдрөөс мөн оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал түр хугацаагаар түдгэлзүүлсүгэй.

2.Дээрх хугацаанд Иргэний нисэхийн ерөнхий газар, түүний харьяа салбар, нэгжийн ажилтан хүндэтгэн үзэх зайлшгүй (хүнд өвчний улмаас гэр бүлийн гишүүнээ асрах) шаардлагаар хүсэлт гаргасан тохиолдолд нотлох баримтыг үндэслэн 3 сар хүртэл хугацаагаар цалингүй чөлөөг тушаалаар олгохыг Иргэний нисэхийн үндэсний төв, түүний харьяа салбар, нэгжийн дарга нарт зөвшөөрсүгэй.

3.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан хууль тогтоомжийн дагуу зохион байгуулалтын арга хэмжээ авч, харьяа салбар нэгжүүдэд мөрдүүлж ажиллахыг Иргэний нисэхийн үндэсний төв (Н.Батсайхан)-д, Захиргаа, удирдлагын газар (Т.Батжаргал)-т тус тус үүрэг болгосугай.

4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газар (Т.Батжаргал)-т даалгасугай.

ДАРГА



Ч.МӨНХТУЯА